

**ОРХОН АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ  
МИЖИДДОРЖ ОВОГТОЙ БАТЦООЖИЙН**

**МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**НЭГ. ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:**


Иргэн бүр Үндсэн хуулиар олгогдсон эрхээ эдэлж, нас, хүйс, шашин шүтлэг, намын харъяалал, угсаа гарал, оршин амьдарч буй газар, нийгмийн байр сууриас үл хамааран хүн бүр эрхэм чанараа мэдрэн, айх аюулгүй, эрх чөлөөтэй, ЭРҮҮЛ ОРЧИНД, ЦАЛИН ОРЛОГОТОЙ амьдарч, сурч боловсрох, хөгжих эрхтэй. Үүнд:

- Бичил бизнес эрхлэгчдэд хууль эрх зүйн мэдлэг, мэдээллийг өгөх хөгжлийн төвийг байгуулж, туршлага солилцох, харилцан уялдаа бүхий бизнесийн үйл ажиллагааг холбож ажиллана.
- Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн чиглэлээр мэргэшүүлэх сургалтуудыг зохион байгуулж, цалинтай орлоготой залуус болоход дэмжинэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бизнес хөгжлийг дэмжиж, орон нутгийн хөрөнгөөр хүүгүй зээл олгох төслийг эрчимтэй хэрэгжүүлнэ.
- Залуусын уулзалт, өдөрлөгийг зохион байгуулж, бизнес инкубатор чиглэлээр бизнесийн орлоготой болгоход чиглэж ажиллана.
- “Иргэд-Иргэдийн төлөөлөл байх” зарчмын хүрээнд иргэдийн хяналтын тогтолцоог бий болгоно.

**ХОЁР. АЙЛ ӨРХИЙН АМЖИРГААГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР:**

Айл өрх бүр эрүүл, аюулгүй орчинд, ашиг орлоготой, амьдралын баталгаатай амьдрах эрхтэй. Үүнд:

- Нийгмийн түншлэл, хамтын ажиллагааны хүрээнд Орхон аймгийн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтөд хяналт тавьж ажиллана.
- Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн хүрэлцээг нэмэгдүүлж, эрүүл мэндийн боловсрол олгох хөтөлбөрүүдийг ЕБС, цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн хүүхдүүдэд зориулан боловсруулж, сурталчилна.
- Гэр хорооллын алслагдсан айл өрхийн хүүхдүүдийн сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр санаачлагатай ажиллаж, хүүхэд бүрийн аюулгүй байдлыг хангаж, боловсролын үйлчилгээ авах таатай нөхцлийг бүрдүүлэх чиглэлээр ажиллана.
- Гэр хороололд амьдардаг айл өрхүүд орчны ногоон хөгжлийг дэмжиж, боловсон 00, сэргээгдэх эрчим хүчээр дулаан цахилгаанаа шийдвэрлэсэн тохиолдолд дэмжлэг үзүүлэх чиглэлийг баримтална.
- Аймгийн хэмжээнд айл өрхийн нийгмийн асуудлыг хариуцсан ажлын хэсгийг байгуулж, өрхийн нийгмийн асуудал, тусламж, дэмжлэгийн асуудлыг хамтран шийдвэрлэдэг болно.
- Өрхийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр хөтөлбөр, төслүүдийг санаачлан хэрэгжүүлэх,
- Өрхийн хадгаламжийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, санхүүгийн мэдлэг, боловсролтой өрх, өрхийн гишүүдийг бий болгоно.
- Сууц өмчлөгчдийн холбоодтой хамтран орчны аюулгүй байдлыг хангах камер хяналтын системийг бүрэн гүйцэтгэнэ.


 М.БАТЦООЖ

**ГУРАВ. АЙМАГ, СУМЫН ХҮРЭЭНД:**

- Гэр хорооллын газрын дахин төлөвлөлтийн ажлыг эрчимжүүлж, цэвэр бохир усны шугамд холбох ажлыг хамтын ажиллагааны хүрээнд гүйцэтгүүлж, тав тухтай таатай орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд чиглэж ажиллана.
- БОЭТ-ийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, шинэ дэвшилтэт эмнэлгийн тусламж үйлчилгээг нэвтрүүлэх,
- Город, гэр хороолол, Дэнж чиглэлд дугуйн замтай болох,
- Орхон аймгийн агаарын болон хөрсний бохирдол, орчны бохирдол, цагаан тоос, дэд бүтцийн асуудлыг цогцоор шийдвэрлэн цэвэр агаар, эрүүл хөрс, ногоон байгууламж бүхий экологийн тэнцвэртэй орчныг бүрдүүлэх,
- Залуучуудад бизнес эрхлэлтийг дэмжих “Гарааны бизнес” хөтөлбөрийг хэрэгжүүлж, тэдэнд зориулсан “Бизнес төв”-үүдийг сум бүрт байгуулах,
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан сувилал, сэргээн засах үйлчилгээг өрхийн эрүүл мэндийн төвүүдийг түшиглэн үзүүлэх, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй дэд бүтцийг бий болгож, нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах,
- Орхон аймаг, орон нутгийн ногоон орчин, гол ус бүхий орчинд иргэдийн оролцоотой байгальд ээлтэй эко хот, аймаг хөтөлбөр хэрэгжүүлэх,
- Иргэд амьдрах таатай эрүүл цэвэр, ногоон технологи бүхий хаягдалгүй орчинг иргэдийн оролцоотойгоор бүрдүүлэх,
- Багууд болон аймаг, сумын төвүүдэд Төр хувийн хэвшлийн оролцоотой хүүхэд, залуучуудын хөгжих орчин нөхцлийг бүрдүүлсэн цэнгэлдэх хүрээлэн, клубууд, урлаг соёлын газрууд, судалгаа шинжилгээ, танин мэдэхүйн үйл ажиллагаа явуулах эрхийг аж ахуйн нэгжүүдэд чөлөөтэй олгох,
- Аймаг, сумын төвүүдэд хөдөө аж ахуйн бүтээгдхүүн, малын гаралтай нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бодлогоор дэмжиж хөгжүүлэх эрх зүйн өөрчлөлтийг хийх,
- Хүнсний аюулгүй байдлыг ханган, малын гаралтай эцсийн бүтээгдэхүүнийг экспортлон малчдын орлогыг төрөлжүүлэн нэмэгдүүлэх зорилгоор малыг эрүүлжүүлэх аяныг өрнүүлэх,
- Сумдад ноос ноолуур, арьс шир, хоёрдогч түүхий эд боловсруулах, жижиг дунд үйлдвэрийг дэмжих,
- Цахим бизнес хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх
- Металл эд ангийн үйлдвэрлэл хөгжүүлэх цогц бодлого хэрэгжүүлэх
- Гадаад зах зээлтэй бизнес эрхлэгчдийг холбож дэмжиж ажиллах

МӨРИЙН ХӨТӨЛБӨР БОДОВСРУУЛСАН:

М.БАТЦООЖ



М.БАТЦООЖ